



НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 07 сарын 03 өдөр

Дугаар А/202

Улаанбаатар хот

Хариуцлагатай эргүүл, жижүүр ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6. "л", 29.2 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ой, Үндэсний их баяр наадмын өдрүүдэд дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн дэг журмыг сахиулах, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дүүргийн Иргэдэд үйлчлэх төв байранд хариуцлагатай эргүүл, жижүүрүүдийг томилон ажиллах хуваарийг хавсралтаар баталсугай.

2. Байгууллага бүр Үндэсний их баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүр томилон ажиллуулахыг дүүргийн нутаг дэвсгэрийн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын дарга, эрхлэгч, хороодын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хуваарийн дагуу хариуцлагатай эргүүл, жижүүрийн үүрэг гүйцэтгэхдээ нутаг дэвсгэрийн байгууллагуудын эргүүл, жижүүрүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж илэрсэн зөрчлийн талаар холбогдох байгууллага албан тушаалтан, Нийслэлийн шуурхай албаны "310005", дүүргийн Онцгой байдлын хэлтсийн 80111189 дугаарын утсанд мэдээлж, шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг хариуцлагатай эргүүл, жижүүрүүдэд үүрэг болгосугай.

4. Хариуцлагатай жижүүрээр ажилласан албан хаагчдыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.3 дахь хэсэгт заасны дагуу нөхөн амруулахыг холбогдох хэлтэс, албадын дарга нарт зөвшөөрсүгэй.

5. Баярын өдрүүдэд хариуцлагатай эргүүл, жижүүрүүд хэрхэн ажилласан талаарх дүн мэдээг нэгтгэж, дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд танилцуулахыг Засаг даргын Тамгын газар /Б.Энхболд/-т үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА



Ж.АЛДАРЖАВХЛАН

1170200633

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2018 оны
 07 дугаар сарын 03-ны өдрийн 4/20 дугаар
 захирамжийн хавсралт



ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖУУР ХИЙХ АЛБАН ХААГЧДЫН НЭР,
 ЦАГИЙН ХУВААРЬ

Д/д	Нэр	Хэлтэс, алба	Өдөр, гариг	Эхлэх хугацаа	Дуусах хугацаа	Утас	Гарын үсэг	Хяналт тавих албан тушаалтны нэр, ажиллах хуваарь	Утас
1	Ц.Чингүүнболд	Цэргийн штаб	VII/11	08.00	20.00	99083202		Хууль зүй, архивын тасгийн дарга	99106291
2	Ц.Ерөөлт	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс	VII/11	20.00	08.00	88813741			
3	Ж.Алтанчимэг	Боловсролын хэлтэс	VII/12	08.00	20.00	99167858		Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга Ц.Бат-Эрдэнэ	99084840
4	Э.Мөнхжаргал	Худалдан авах ажиллагааны алба	VII/12	20.00	08.00	91159949			
5	Б.Тодмаа	Статистикийн хэлтэс	VII/13	08.00	20.00	95973854		Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Лхагвабаатар	91116572
6	Г.Тулга	Дотоод аудитын алба	VII/13	20.00	08.00	88811777			
7	Н.Баярхүү	Нийгмийн бодлогын хэлтэс	VII/14	08.00	20.00	94947535		Санхүү, төрийн сангийн хэлтэс М.Цогзолмаа	99114608
8	Б.Содномцэрэн	Бүртгэлийн хэлтэс	VII/14	20.00	08.00	94000711			
9	О.Мөнгөншагай	Эдийн засаг төлөв- лөлтийн хэлтэс	VII/15	08.00	20.00	99178551		Нийгмийн бодлогын хэлтсийн дарга Б.Мэндбаяр	99723867
10	О.Орхонжаргал	Газрын алба	VII/15	20.00	08.00	99806065			